

ШУТИС-ИЙН ПРОФЕССОР, БАГШ НАРЫН
“ЭРДМИЙН ЧУУЛГАН-2019”-Ы УДИРДАМЖ

1. Зорилго: ШУТИС-ийн профессор, багш нарын гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хэлэлцэх, сурталчлах, харилцан туршлага солилцох, залуу судлаачдыг дэмжихэд оршино.

2. Хамрах хүрээ: ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, харьяа болон бүрэлдэхүүний хүрээлэн, эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн профессор, багш, залуу судлаач, эрдэм шинжилгээний ажилтан

3. Эрдэм шинжилгээний хурлын чиглэл:

- Техник-технологи
- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан
- Нийгэм, хүмүүнлэгийн ухаан

4. Нийтлэг шаардлага:

- 2017, 2018 онуудад гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн байх;
- Урьд нь хэвлэн нийтлэгдээгүй бүтээл байх;
- Сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлсон, баримт нотолгоонд тулгуурласан, шинэлэг санаа, практик ач холбогдол, түүний хэрэгцээг тодорхойлсон дүгнэлттэй байх;
- Бүтээлд гадаад, дотоодын эх сурвалж /12-оос доошгүй эшлэл хэрэглэх/-ийг ашигласан байх, бусдын бүтээлийг ашиглахдаа эх сурвалжийг заавал дурдсан байх;
- I шатанд хэлэлцүүлж шалгарсан бүтээл байх /захирлын албан бичгээр баталгаажуулах/;
- Тухайн салбарын 2-оос доошгүй эрдэмтдээс шүүмж авсан байх;
- ШУТИС-ийн Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.
Холбоос: <http://www.must.edu.mn/static/uploads/files/hawsralt1-2.pdf>

5. Хугацаа, үе шат:

I шат: Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгүүд *2019 оны 2 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд* профессор, багш нарын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

II шат: Профессор, багш нарын “Эрдмийн чуулган - 2019” эрдэм шинжилгээний нэгдсэн хурал *2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 09 цагаас* ШУТТНСангийн E-604 тоот хурлын танхимд болно.

Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн тус бүрээс II шатанд оролцох 3 хүртэлх шилдэг өгүүллийг *2019 оны 2 дугаар сарын 19-ний дотор* Эрдэм шинжилгээ, инновацийн газарт хэвлэмэл болон файлаар research@must.edu.mn цахим хаягаар албан бичгийн хамт ирүүлнэ.

6. Эрдэм шинжилгээний хурлын шагнал, урамшуулал:

- Техник-технологи:

I байр – Батламж, 1 сая төг
II байр – Батламж, 700 мян.төг
III байр – Батламж, 500 мян.төг

- Байгалийн ухаан, хэрэглээний шинжлэх ухаан:

I байр - Батламж, 1 сая.төг
II байр – Батламж, 700 мян.төг
III байр – Батламж, 500 мян.төг

- Нийгэм, хүмүүнлэгийн ухаан:

I байр – Батламж, 1 сая.төг
II байр – Батламж, 700 мян.төг

7. Бүтээлийг нийтэд түгээн дэлгэрүүлэх:

Хуралд хэлэлцүүлсэн өгүүллийн эмхэтгэлийг Эрдэм шинжилгээ, инновацийн газраас эрхлэн гаргаж, олны хүртээл болгох, таниулах ажлыг зохион байгуулна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИЙН ГАЗАР